

ЗҮҮН ХОЙД АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД МОНГОЛ, ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

*Н.Төмөр**

Монгол Улс, БНХАУ хоёр улсын эдийн засгийн хөгжил Зүүн хойд Азийн эдийн засгийн хөгжилд шууд нөлөөлөх нь дамжиггүй бөгөөд Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа нь тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой. Холбогдох мэргэжилтнүүдийн тооцоолсноор, энэ бүс нутгийн хэтийн төлөв нь нэлээд урт хугацааны турш, хоёр талын хамтын ажиллагаагаар голлох юм байна.

Өнөө үед дэлхийн эдийн засгийн хөгжлийн нэг гол төлөв болсон Ази, Номхон далайн бүс нутаг нь Зүүн хойд Ази, Зүүн өмнөд Ази гэсэн дэд бүсүүдээс бүрэлдэж байна. Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутагт тухайлбал, Зүүн хойд Азийн бүс нутагт өрнөж буй эдийн засгийн интерграцийн үйл явцад идэвхитэй оролцон, тус бүс нутгийн улс орнуудтай хоёр талын харилцаагаа өрнүүлэн хөгжүүлж байгаа билээ.

Газар зүйн байршлаараа Монгол Улс Ази, Европыг холбосон, өөрөөр хэлбэл Зүүн хойд Азийн улс орнуудыг Төв Ази, Баруун Ази болон Европын улсуудтай холбох чухал гүүр болно. Ази, Европыг холбосон энэ гүүрийг сайн ашиглаж чадвал Монгол Улсын хөгжилд төдийгүй, Зүүн хойд Ази, улмаар дэлхийн эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр болох юм.

Монгол Улс өргөн уудам газар нутагтай, байгалийн нөөц баялаг ихтэй. Монгол орон төрөл бүрийн ашигт малтмалаар баян бөгөөд нүүрс, алт, зэс, гянтболд, хөнгөн цагаан, молибден, хайлуур жонш, давс, фосфор, үнэт чулуу, барилгын материалын ихээхэн нөөцтэй улс юм. Монгол Улс малын бэлчээрээр дэлхийн тэргүүний эгнээнд ордог. Монгол Улс нь хөгжлийн асар их ирээдүйтэй орон бөгөөд Зүүн хойд Азийн бүс нутгийнхаа эдийн засгийн хамтын ажиллагаанд нэлээд чухал байр эзэлдэг.

Монгол Улс бол далайд гарцгүй орон учир Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудтай тухайлбал, БНХАУ-тай эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаа бүх талаар хөгжүүлэх нь Монгол Улсын эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр БНХАУ-д 2009 оны 4 дүгээр сард айлчлах үеэр Монгол Улсын Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам, Тяньжин хотын захиргааны хооронд Тяньжин хотын Бинхай шинэ дүүрэгт Монгол, Хятадын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд

* Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

мөн оны 10 дугаар сард Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулах “Улаанбаатар төлөөлөгчийн газар”-ыг Тяньжин хотод байгуулан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. “Улаанбаатар төлөөлөгчийн газар” нь Тяньжин хотын Бинхай шинэ дүүргийн Дунзяны гаалийн баталгаат боомт бүсийн захиргаатай харилцан тохиролцож, тус боомт бүсэд тээвэр ложистикийн хамтарсан компани байгуулан, улмаар тээвэр ложистикийн төв байгуулах., жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ /хөнгөн үйлдвэрлэл, сав баглаа боодол/ явуулах, мах, махан болон хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, дамжуулан борлуулах, улмаар хөргүүлтэй агуулахын аж ахуй байгуулах, аялал жуучлал зохион байгуулах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг тогтоожээ.

Монгол Улс ба БНХАУ хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр тогтвортой хөгжиж байна. Хоёр орны өндөр түвшинд хүрсэн улс төрийн харилцааг эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаар улам баталгаажуулж байдаг бөгөөд Монгол Улс, БНХАУ-ын бүх талын харилцааг тогтвортой хөгжүүлэх явдлыг гүнзгийрүүлэхэд дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, уулзалт чухал ач холбогдолтой.

БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар 2003 онд Монгол Улсад төрийн айлчлал хийсэн. Төрийн айлчлалын үеэр хоёр улсын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлэхээ санал нэгтэй мэдэгдэв. Айлчлалын үеэр хоёр улс харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, хамтын ажиллагааг олон салбар, сувгаар, төрөл бүрийн хэлбэрээр өрнүүлэн, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, уул уурхайн болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, байгалийн баялгийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор тохиролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн урилгаар 2005 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Айлчлалын үеэр гаргасан Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэлд, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа бол Монгол, Хятадын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг мөн гэж талууд санал нэгтэй үзэв. Хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц гарч байгаад сэтгэл ханамжтай байгаагаа талууд илэрхийлж, цаашид байгалийн баялгийг нээн ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг гол болгосон харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хоёр талын худалдаа, эдийн

засгийн хамтын ажиллагааг шинэ агуулга, хэлбэрээр баяжуулах, хамтаар хөгжихийн төлөө цаашид хүчин чармайлт гаргахаа талууд санал нэгтэй илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр 2009 онд Баогийн форумд оролцон, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Жябаотой Саньяа хотод уулзаж, Монгол Улс, БНХАУ-ын найрамдалт харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар ярилцав. Ерөнхий сайд С.Баяр дэд бүтцийн болон байгалийн баялгийг ашиглах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрчим хүчний цогцолбор барьж БНХАУ-д цахилгаан эрчим хүч экспортлох, нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах талаар саналаа илэрхийлэв. Тэрээр хэлэхдээ, хоёр улсын хилийн боомтуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, Хятад улсын нутгаар дамжин далайд гарах нь БНХАУ-тай хийх худалдаанд төдийгүй Ази, Номхон далайн орнуудын зах зээлд гарах боломжийг нэмэгдүүлэх юм гэж онцлон тэмдэглэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ-ын дарга Ху Жинтаогийн урилгаар 2010 онд БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Албан ёсны уулзалтууд, хэлэлцээний үеэр хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал чухал байр суурь эзэлсэн. Хоёр орны хоорондын худалдааг нэмэгдүүлэх, уул уурхай, дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар хоёр орны удирдагчид санал нэгтэй тохиролцлоо. Тухайлбал, манай улсад уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийг гүн боловсруулж Хятадын болон гуравдагч орны зах зээлд нийлүүлэх, транзит тээврийн асуудалд, далайд гарах боомт гарцыг нэмэгдүүлэх зэрэг гол гол асуудлыг манай талаас тавьсан бөгөөд Хятадын тал дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн болно. Монгол Улсын Ерөнхийлөгч БНХАУ-д хийсэн төрийн айлчлалын хугацаанд Хятадын Зүүн хойд хэсэгт орших Жилинь мужид зочилсон. Зүүн хойд Азийн хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг энэ муж нь манай улстай хамтран ажиллах, харилцаагаа өргөжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байдаг бөгөөд айлчлалын үеэр тус муж, манай улсын Дархан-Уул аймгийн хооронд шууд харилцаа тогтоож, цаашид тодорхой салбаруудад хамтран ажиллах тухай баримт бичигт гарын үсэг зурсан.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд 2011 оны 6 дугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай хамтарсан мэдэгдэл гаргасан. Уг мэдэгдэлд Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны талаар дурдахдаа, “Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлж, харилцан ашигтай, хамтаар хожих хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлж,

хамтын хөгжлийг урагшлуулах нь Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны өнө удаан хугацааны хөдөлгөгч хүч байх болно. Өөрийн улсын эдийн засгийн хөгжлийн стратегийн үндсэн дээр хоёр талын худалдааны бүтцийг сайжруулж, харилцан хөрөнгө оруулалтыг дэмжиж, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлтийг хадгалахаа талууд илэрхийлэв” гэж тэмдэглэжээ.

БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны томоохон түншүүдийн нэг бөгөөд хоёр орны эдийн засаг, гадаад худалдааны харилцаа жилээс жилд улам бүр өргөжин хөгжсөөр ирлээ. Монгол, Хятадын гадаад худалдааны хэмжээ 2009 онд 1932.5 сая ам.доллар, 2010 онд 3437.2 сая ам.долларт хүрсэн нь үүнийг харуулсан нэг баримт болно. 1990 оноос Монгол Улсад гадаад орнуудаас оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ тэргүүлэх байр эзэлж байна.

Монгол, Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чухал салбарууд нь уул уурхайн үйлдвэр, дэд бүтцийн барилга байгууламж юм. Тухайлбал, Ховд аймгийн Дөргөн сумын нутагт байрлах Дөргөний усан цахилгаан станцыг БНХАУ-ын Гадаадын эдийн засаг, технологийн хамтын ажиллагааны Шанхай корпорацн барьж дуусган, 2010 оны 1 дүгээр сарын 28-нд Монгол Улсын Засгийн газарт албан ёсоор хүлээлгэн өгсөн. Дөргөний УЦС-ын суурилагдсан хүчин чадал 12 мвт, жилд 38.0 сая квт/цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх юм. Сүхбаатар аймгийн нутагт орших Төмөртийн овооны цайрын ордод жилд 300 мянган тн хүдэр олборлон, 70 орчим мянган тн цайрын баяжмал бэлдэх хүчин чадалтай Монголын “Металлимпекс” ХХК, БНХАУ-ын Өнгөт төмөрлөгийн барилга, зураг төслийн компанитай Монгол, Хятадын хамтарсан үйлдвэр байгуулж, 2005 онд ашиглалтанд оржээ. Сүүлийн жилүүдэд БНХАУ-аас хамгийн ихээр хөрөнгө оруулж буй салбарын нэг бол газрын тосны геологи хайгуул, олборлолт юм. БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Петрочайна Дачин Тамсаг /Монгол/” ХХК нь Дорнод аймгийн нутаг дахь Тамсагбулагт 2005 оноос үйл ажиллагаагаа явуулж байна.

Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд Монгол Улсын дорнод бүс нутагт орших Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг аймгууд, БНХАУ-ын зүүн хойд хэсэгт орших Хар мөрөн, Жилинь, Ляонин зэрэг мужууд болон ӨМӨЗО нь газар зүйн байршлаар чухал ач холбогдолтой байна. Энэхүү бүс нутгийн газар зүйн давуу нөхцлийг гүйцэд ашиглан хоёр тал, улмаар Зүүн хойд Ази болон дэлхийн бусад улс орнуудыг эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажилдаа оролцуулж, хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлж болох юм.

Зүүн хойд Азийн эдийн засгийн олон талын хамтын ажиллагааны бүс буй болгоход дөхөм үзүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн

Хөтөлбөр /UNDP/ 1991 онд Түмэн голын эдийн засгийн хөгжлийн бүс байгуулах төслийг боловсруулан, Түмэн голын билчирийн сав дахь БНХАУ-ын Хуньчуний эдийн засгийн чөлөөт бүс, БНАСАУ-ын Ражин, ОХУ-ын Владивосток, Посьет, Находка, БНСУ-ын Пусан зэрэг боомт хотуудыг хамарсан транзит худалдаа, тээвэр хийгээд олон төрлийн үйлдвэрлэлийн дэлхийн хэмжээний ач холбогдолтой том төв буй болгох зорилго дэвшүүлсэн. Тухайлбал, Хуньчунь-Зарубино-Пусан чиглэлийн бараа тээвэрлэлтийн шугам, Хуньчунь-Ражин-Пусан чиглэлийн тээвэрлэлтийн шугам, Хуньчунь-Посьет чиглэлийн зорчигч бараа тээвэрлэлийн шугам зэргийг дурдаж болно. Монгол Улсын хувьд бол ийм их ирээдүйтэй дэд бүстэй тээвэр худалдааны шууд харилцаатай болохоос гадна Ази, Европыг холбох авто замын сүлжээнд оролцох, мөн далайн тээвэр ашиглах нэмэгдэл бололцоо олдох юм. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар 2010 оны 4 дүгээр сард БНАСАУ-д албан ёсны айлчлал хийж, айлчлалын үеэр Ражин боомтыг ашиглах тухай Санамж бичигт гарын үсэг зурав.

Аливаа улс орны эдийн засаг хөгжих чухал нөхцөл бол зам харилцаа юм. Иймээс Монгол Улс Дорнод бүс нутгаа хөгжүүлэхдээ, юуны өмнө зам тээврээ хөгжүүлбэл зохих бөгөөд тухайлбал, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос БНХАУ-ын ӨМӨЗО-ны Рашаант хот хүртлэх төмөр замыг барьж байгуулснаар Чойбалсан хотыг Хятадын Хуньчунь хоттой төмөр замаар холбох боломжийг буй болгон улмаар БНСУ-ын Пусан, БНАСАУ-ын Ражин, ОХУ-ын Посьет зэрэг боомт хотуудтай төмөр замаар холбох боломжтой болно. Ингэснээр Монгол Улс далайд хэд хэдэн гарцтай болж, гадаад хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, ашигт малтмалаа ашиглах, гадаадын жуулчдыг олноор ирүүлэх шинэ боломжийг бий болгоно.

Монгол Улс нүүрсээр нэлээд баялаг учир нүүрсээ цахилгаан эрчим хүч болгон /дулааны цахилгаан станц байгуулах/ Зүүн хойд Азийн шаардагдах орнуудад өндөр хүчдэлээр БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан хүргэх талаар судлалгаа хийж болох юм. Ингэвэл Зүүн хойд Азийн улс орнуудын эдийн засгийн хөгжилд их тус болохоор барахгүй, Монгол Улсын үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардагдах эрчим хүчийг бий болгон эдийн засгийн их ашигтай байх болно.

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхэд Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. L.Dondog, S.Lhagva. Mongolia: Foreign Investment, Trade and Tourism, UB. 1996.
2. Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл, Улаанбаатар хот, 2003 оны 6 дугаар сарын 5-ны өдөр
3. “Өдрийн сонин”, 2003.06.05-06., 2004.07.07-08., 2005.07.22., 08.13
4. “Business Times”, 2003.№1 (308)
5. “人民日报” 2003.06.06., 2004.07.06
6. “Монголын уул уурхайн аж үйлдвэр 80 жилд”, УБ., 2002.
7. “Зүүн бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр”, УБ., 2004
8. Монгол Улс, БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл, Бээжин хот, 2005 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр
9. “Erina Report” сэтгүүл, Vol.64, 2005. July
10. “Өнөөгийн Хятад” сэтгүүл, 2005.№1
11. The Investment Forum Attracting Investment For Growth in the Greater Tumen Region (Changchun, 2-6 Sep, 2005)
12. “Новости Монголии”, №41, 14 Октября 2005 года
13. 天津滨海新区的成长与展望,天津社会科学院出版社 2008
14. <http://www.ubtg.gov.mn>
15. “Өдрийн сонин” 2009.04.20, “UB Post” 2009.04.21
16. <http://www.iyaxin.com> 2010.01.29
17. <http://www.mglradio.com> 2010.04.23
18. <http://www.mfat.gov.mn> 2010.05.04
19. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай хамтарсан мэдэгдэл, Бээжин хот, 2011.06.16
20. “Монгол Улсын статистикийн эмхтгэл 2010”, УБ, 2011